



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

310 дугаар байр, Лувсанданжандангийн өргөн чөлөө 3,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум, Баянхонгор
аймаг, 64101, Утас:(976) 70443206,
Цахим шуудан: mlrkhsaikhan@bvalkhongor.gov.mn
Цахим хаяг: www.bvalkhongor.gov.mn

᠒᠙᠑5.01.᠒3 № 1᠙11᠒

Танай _____ -ны № _____ -т

СҮМ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА
НАРТ

Авлигатай тэмцэх газраас санаачлан жил бүр
аймгийн шударга байдлын үнэлгээг хөндлөнгийн
байгууллагаар хийлгэдэг.

Энэ хүрээнд аймгийн шударга байдлын үнэлгээг
өмнөх оноос ахиулах төлөвлөгөө боловсруулан
хүргүүлж байна.

Иймд шударга байдлын үнэлгээг ахиулах
зорилгоор төлөвлөгөө боловсруулан хүргүүлж байна.

Холбогдох арга хэмжээг хариуцлагатайгаар авч
хэрэгжүүлэн хариуг эхний хагас жилд 2025 оны 05
дугаар сарын 10-нд, сүүлийн хагас жилд 11 дүгээр
сарын 10-ны дотор Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлэхийг
мэдэгдье.

Хавсралт: Хуудастай

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН



624061117

**БАЯНХОНГОР АЙМГИЙН “ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”-Г 2025
ОНД САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**



 БАТЛАВ
 БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
 ДАРГА Д.МӨНХСАЙХАН
 2025 оны 01 дүгээр сарын 23

2025 оны 01 дүгээр сарын 23

НОМГОН

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах газар, хэлтэс
1.	Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр Баянхонгор аймгийн ИТХ, ЗДТГ-ын харьяа байгууллага, сумдуудын цахим хуудас, мэдээллийн самбар дахь /цахим/ үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод, нээлттэй эсэхэд дүн шинжилгээ хийх, бүрэн бус мэдээллүүдийг нэмж байршуулах, тогтмол шинэчлэх; /2022 оны мэдээлэлтэй/	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг ил тод байршуулсан байна.	2025.01.01- 2025.11.10	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
2.		- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3-аас доошгүй удаа тухайн байгууллагын талаар мэдээлэл гарсан байх; -Олон нийтийн цахим сүлжээ /фейсбүүк, ютүб, твиттер, инстаграмм, цахим хуудас/ зэрэгт тухай бүр мэдээлэл байршуулсан байх; -Ур дүнд үндэслэн тогтмол дүн шинжилгээ хийсэн байх;	2025.01.01- 2025.11.10	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд

1	2	3	4	5	6
3.		Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, мэдээллийн цахим сан үүсгэж үйл ажиллагаандаа ашиглах замаар үйлчилгээний чанар хуртээмжийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх.	Олны танил 3-аас доошгүй хүмүүсээр байгууллагын сурталчилгааг хийлгэсэн байх;	2025.01.01-2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн Цахим үйлчилгээний хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
4.		Аймгийн ЗДТГ, харьяа байгууллага, сумдын албан хаагч нар иргэдтэй хүндэтгэлтэй харьцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг бүрэн дүүрэн, үнэн зөв тайлбарлан өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахыг хориглох, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэн давуу байдал бий болгохгүй байх, хувийн ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;	-Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх; - Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх;	2025.01.01-2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
5.		Байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хуртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;	-Тандалт ажиглалтыг сар бүр зохион байгуулсан байх; -Зөрчил дутагдлыг арилгах зорилгоор нэгжийн удирдлагад үүрэг чиглэл тухай бүр өгсөн үр дүнг тооцсон байх;	Сар бүр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд

1	2	3	4	5	6
6.		Албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа авах нь авлигын зөрчил болох талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг дотооддоо тусгайлан зохион байгуулах (контент бүтээх, кейс бүхий дэвжээ, АХА бусад уралдаан тэмцээн зохион байгуулж болно.),	-Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	2025.01.01- 2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
7.		Аймгийн ЭДТГ, харьяа байгууллагын албан хаагч нар албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад дотоод сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	-Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	2025.01.01- 2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
8.	Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар баримттай албан хаагчийг удирдлагын зүгээс хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ нийт албан хаагчдад илэрхийлэх;	-Авлигын зөрчлийн талаар мэдээлэл өгөх сувгуудыг сурталчилсан байх; -Мэдээ, мэдээллийн мөрөөр хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, буруутай албан хаагчдад хариуцлага тооцсон байх;	2025.01.01- 2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
9.		Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээ авах, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг бодитой авч хэрэгжүүлэх;	-Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; -АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байх;	2025.01.01- 2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
10.		Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулалтыг үр, ашигтай байлгах зөвхөн хууль журамд заасан үндэслэлээр зарцуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах,	-Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн байх -Зарцуулалтын тайланг ил тодоор мэдээлэх	2025.01.01- 2025.11.10	Сум, байгууллагуудыг нягтлан бодогч

1	2	3	4	5	6
		зарцуулалтын тайланг ил тод байлгах талаар анхаарч ажиллах			Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
11.	Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр	Байгууллагын удирдах албан тушаалтан нийт алба хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн албан улзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах;	-Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн улзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх;	2025.01.01-2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
12.		Аймгийн ЗДТГ, харьяа байгууллагын дарга нарын тушаал, шийдвэрээр албан хаагч нарт чөлөө олгож байгаа байдалд газар, хэлтэс, сум тус бүрээр дүн шинжилгээ хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	-Газар, сум тус бүрт дүн шинжилгээ хийсэн бүрт дүн шинжилгээ хийсэн байх, -Үр дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ авсан байх,	2025.01.01-2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
13.		Аймгийн ЗДТГ-ын харьяа байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагч нар нь Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тогтоосон "Албан тушаалын тодорхойлолт"-д нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;	-Газар, сум тус бүрт дүн шинжилгээ хийсэн байх, -Үр дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ авч шалтгаан нөхцөлийг арилгасан байх,	2025.01.01-2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
14.		Аймгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилтийг бүрэн хангуулж авлига үүсэх нөхцөлийг арилгах чиглэлээр түүнд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тогтмол албан хаагч нарт хүргэж зохих мэдээллээр хангах арга хэмжээ авах;	-Дүрэм, журмын хэрэгжилтэд тодорхой хугацааны дотор хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байх, -Шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байх;	2025.01.01-2025.11.10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймаг, сумдын төрийн байгууллагууд
15.		Албан хаагчдын ажлын цаг баримтлалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах	-Ажлын цаг баримтлал, ашиглалтад дүн шинжилгээ хийж холбогдох арга	2025.01.01-2025.11.10	Сум, байгууллагууды н нягтлан бодогч

1	2	3	4	5	6
			Хэмжээ авч ажилласан байх		Сум, байгууллагууды н удирдлагууд
16.		Албан хаагчдын ажлын үр дүнг шударгаар үнэлэхэд анхаарч хууль, журмын хүрээнд үр дүнтэй ажил зохион байгуулах	-Албан хаагчдын ажлын үр дүнг шударгаар үнэлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байх	2025.01.01- 2025.11.10	
17.		Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	-Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх -Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх	2025.01.01- 2025.11.10	Төрийн захираа удирдлагын хэлтэс

...000...